БАТЛАВ.
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ТӨМӨРХҮҮ

**“БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨРСНИЙ УСНЫ ХАМГААЛАЛТ” БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Дугаар: 14/2024 Улаанбаатар хот

| | |
|---|---|
| 1. Төсөл боловсруулах үндэслэл: | - Барилгын тухай хуулийн 34.1.2 дахь заалт;<br>- Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн норм, норматив баримт бичгийн ерөнхий тогтолцоо”;<br>- “Барилга байгууламжийн норм, нормативын сан”-гийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний 2 дугаарт тусгагдан батлагдсан. |
| 2. Төслөөр шийдвэрлэх асуудлууд: | 1. Энэхүү баримт бичгийг шинээр боловсруулснаар бүх төрлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах болон барилгын ажил гүйцэтгэх үе шатанд барилга байгууламжийг хөрсний уснаас хамгаалах асуудлыг шийдвэрлэх олон улсын жишигт нийцсэн баримт бичигтэй болно. |
| 3. Төслийн бүрдэл: | Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:<br>1. Хамрах хүрээ;<br>2. Нормативын эшлэл;<br>3. Нэр томьёо ба тодорхойлолт;<br>4. Ерөнхий зүйл;<br>4.1. Суурийн хүнхээл, шуудуу ба газар доорх ажлын хамгаалалтын системд тавих шаардлага;<br>4.2. Хөрсний устай нөхцөлд ашиглагдах байгууламжийн хамгаалалтын системд тавигдах шаардлага;<br>Хамгаалалтын системийн ангилал<br>4.3. Газар доорх уснаас хамгаалах аргыг зураг төсөлд тусгах өгөгдлүүд;<br>4.4 Газар доорх уснаас хамгаалах зураг төслийн тооцооны гидрогеологийн өгөгдлүүд;<br>5. Инженерийн гидрогеологийн судалгаа;<br>5.1 Барилга байгууламжийг газар доорх уснаас хамгаалах аргыг сонгох зарчим;<br>5.2 Аналитик тооцоо;<br>5.3 Хөрсний шүүрүүлэлтийн математик загварчлал;<br>6. Хөрсний усны түвшин доошлуулах зураг төсөл боловсруулах<br>6.1 Ерөнхий шаардлага;<br>6.2. Хөрсний усны түвшин доошлуулах системийн ерөнхий заалт;<br>6.2.1. Хөрсний усны түвшин доошлуулах цооног;<br>6.2.2. Хөрсний усны түвшин доошлуулах цооногийн системийн тооцоо; |

| | |
|---|---|
| | 6.2.3. Шүүрүүлэлтийн иньекцийн төхөөрөмж;<br>6.2.4. Хөрсний усны түвшин доошлуулах шүүрүүлэлтийн иньекцийн системийн тооцоо;<br>6.2.5. Шүүрүүлэлтийн эсрэг ханан хөшгийн зураг төсөл боловсруулах;<br>7. Анхдагч буюу А төрлийн хамгаалалтын системийн зураг төсөлд тавигдах шаардлага<br>7.1. Ерөнхий заалт;<br>7.2. Бүтээцлэлийн арга хэмжээ;<br>7.3. Технологийн арга хэмжээ;<br>7.4. Бетон хольц ба бетон бүтээцэд тавигдах шаардлага;<br>8. Хоёрдогч хамгаалалт буюу В төрлийн хөрсний ус тусгаарлалтын системийн зураг төсөлд тавигдах шаардлага.<br>8.1. Хөрсний ус тусгаарлалтын системийн тухай ерөнхий заалт;<br>8.2. Хөрсний ус тусгаарлалтын бүтээцийн ангилал;<br>8.3. Хөрсний ус тусгаарлах бүтээцийн зураг төсөл боловсруулах анхдагч өгөгдөл;<br>8.4. Хөрсний ус тусгаарлалтын бүтээцлэл ба хэрэглэх нөхцөл;<br>8.5. Хөрсний ус тусгаарлагчийн төрөл сонголт;<br>8.6. Хөрсний ус тусгаарлалтын бүтээцлэлд тавигдах шаардлага;<br>8.7. Хэв гажилтын заадасны чигжээсний ус тусгаарлалтад тавигдах шаардлага;<br>9. Гуравдагч хамгаалалт буюу С төрлийн дренажийн системийн зураг төсөлд тавигдах шаардлага<br>9.1. Ерөнхий заалт;<br>9.2. Усыг шүүрүүлж урсгах /дренажийн/ систем;<br>9.2.1. Хоолой хэлбэрийн усыг шүүрүүлж урсгах /дренажийн/ системийн тооцоо;<br>9.2.2. Мембрантай хөндийт усыг шүүрүүлж урсгах /дренажийн/ систем;<br>9.2.3 Мембрангүй хөндийт усыг шүүрүүлж урсгах /дренажийн/ систем;<br>10. Суурийн бүтээцийг зэврэлтээс хамгаалах шаардлага<br>11. Ус тусгаарлалтын ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага<br>А ХАВСРАЛТ. (зөвлөмж) Барилгын бүтээцийн ус тусгаарлалтын зориулалттай орчин үеийн битум суурьтай материал<br>Б ХАВСРАЛТ. (зөвлөмж) Хөрсний ус тусгаарлалтын орчин үеийн нэвчүүлэх материал<br>В ХАВСРАЛТ. (зөвлөмж) Хөрсний ус тусгаарлалтын орчин үеийн хуйлмал материал<br>Г ХАВСРАЛТ. (зөвлөмж) Хөрсний ус тусгаарлалтын орчин үеийн полимер суурьтай материал |
| 4. Ашиглах материал | 1. ОХУлсын СП 250. 1325800-2016. Свод правил здания и сооружения. Защита от подземных вод” норм, нормативын баримт бичгийг суурь материал болгох |
| 5. Төслийг хэрэгжүүлэх байгууллага: | - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам<br>- “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ |

| | |
|---|---|
| 6. Төслийг гүйцэтгэх байгууллага: | “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах замаар сонгоно. |
| 7. Төслийг боловсруулж дуусгах хугацаа: | 2025 оны IV улирал |
| 8. Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ: | Урьдчилсан тооцоогоор **33 674 500** (гучин гурван сая зургаан зуун далан дөрвөн мянган таван зуун) төгрөг. Санхүүжилтийн эх үүсвэр нь “Барилга байгууламжийн норм, норматив сан” |
| 9. Онцгой нөхцөл: | Салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа энэ төрлийн норматив баримт бичгийн үг хэллэг, утга агуулгатай уялдаж нийцсэн байх. Тухайлбал:<br>✓ “Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага” /БНбД 20-01-11/-ын шаардлагыг хангахаар гүйцэтгэх;<br>✓ “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” /БНбД 22.01.21/-тай нийцүүлэх;<br>✓ “Барилгын ул, хөрсний зондчилолын ажил” /БНбД 3.02.05-89/;<br>✓ “Барилга, байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох” /БНбД 50-01-16/;<br>✓ “Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил” /БНбД 50-02-17/;<br>✓ “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” /БНбД 11-07-19/;<br>✓ Барилгын инженер-геологи, геотехникийн судалгаа /БНбД 11-03-21/;<br>✓ “Монгол орны нутаг дэвсгэрт тархсан олон жилийн цэвдэг хөрсөнд инженер-геологийн судалгаа хийх заавар” /БД 50-102-08/;<br>✓ “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох барилгын норм ба дүрмийн тайлбар дүрэм” /БД 50-103-21/;<br>✓ Барилгын инженер-геологийн тайлан дүгнэлт бичих заавар /БД 11-107-10/;<br>✓ Монгол орны нутаг дэвсгэрт овойлттой ул хөрсний геотехникийн үнэлгээ боловсруулах заавар /БД 11-111-13/;<br>✓ Монгол орны нутаг дэвсгэрт хөөлттэй ул хөрсний геотехникийн үнэлгээ боловсруулах заавар /БД 11 112-13/;<br>✓ Байран гаралтай ул хөрсөнд инженер-геологийн судалгаа хийх заавар /БД 11-116-16/;<br>✓ Барилгын норм ба дүрмийн үг хэллэг, бичиглэлийг MNS1-2:2022 стандартын дагуу боловсруулах<br>✓ Бусад хөгжингүй орны норматив баримт бичигтэй харьцуулж судлах;<br>✓ Тухайн үеийн шинээр батлагдсан тогтолцоотой уялдуулах;<br>✓ Ижил төстэй Еврокодтой харьцуулсан судалгаа хийж, дүгнэлт гаргах;<br>✓ Боловсруулагдах байгаа баримт бичгийн төсөл нь техникийн даалгаврын төслийн бүрдэлд тусгагдсан агуулгатай байхаас гадна боловсруулалтын явцад төслийг ойлгомжтой, эмх цэгцтэй, нэмэлт мэдээлэл тусгагдахаар |

| | |
|---|---|
| | сайжруулалт хийх тохиолдолд захиалагчтай зөвшилцөж өөрчлөлт орж болно;<br>✓ Боловсруулж буй баримт бичигтэй холбоотой иж бүрэн мөрдөгдөх нөхцөлийг хангах дагаж гарах баримт бичгийн жагсаалт, хүчингүй болох баримт бичгийг захиалагчид зөвлөмж байдлаар ирүүлэх;<br>✓ Монгол Улсын барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа баримт бичгийн бүлэг, зүйл, заалтуудтай давхардал үүсгэх, зөрчилдөхгүй байх тал дээр анхаарч судлах.<br>Ашиглах материал: СП 250. 1325800-2016. Свод правил здания и сооружения. Защита от подземных вод” |

## “БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨРСНИЙ УСНЫ ХАМГААЛАЛТ” БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨВ

| № | Хийх ажлын нэр | Хөдөлмөр зарцуулалт, хүн/өдөр | | | Шаардагдах зардал /төгрөг/ | Хянасан |
|---|---|---|---|---|---|---|
| | | Ажиллах хүн/өдөр | Нэгж хүн өдрийн үнэлгээ /төгрөг/ | Зөвлөх багт ажиллах хүний тоо | | |
| 1 | “Барилга байгууламжийн хөрсний усны хамгаалалт” барилгын норм ба дүрмийг техникийн даалгаврын төслийг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх | 14 | | 19 | 1,940,000 | |
| 2 | Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажлыг эхлүүлэх зардал | 24 | | | 400,000 | |
| 3 | Олон улсад хэрэглэгдэж байгаа энэ төрлийн норматив баримт бичгийг судалж, танилцан үнэлэлт дүгнэлт гаргаж эхний тайлан ирүүлэх | 30 | *117,764* | 2 | 7,065,840 | |
| 4 | Судалгааны материалын үр дүнг цэгцэлж эх материалыг Монгол хэлнээ хөрвүүлэх | 30 | *117,764* | 2 | 7,065,840 | |
| 5 | Хөрвүүлсэн ажлыг цэгцлэн бусад норматив баримт бичигтэй уялдуулан боловсруулсан төслийг тайлангийн хамт захиалагчид ирүүлэх | 22 | *117,764* | 2 | 5,181,616 | |
| 6 | Боловсруулсан төслийг захиалагчийн шаардлагыг хангах түвшинд хянаж, бэлэн болгосон төслийг тайлангийн хамт захиалагчид ирүүлэх | 15 | *117,764* | 2 | 3,532,920 | |
| Гүйцэтгэгчид олгох нийт мөнгөн дүн /төгрөг/ | | | | | **25,186,216** | |
| 7 | Нормын төслийг хянан тохиолдуулах | 30 | *117,764* | 1 | 2,300,000 | |
| 8 | Нормын төсөлд шүүмж хийх | 35 | *117,764* | 1 | 3,500,000 | |
| 9 | Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх | - | | 19 | 1,940,000 | |
| 10 | Салбарын шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх | - | | 21 | 420,000 | |
| | Бүгд | | | | 33,346,216 | |
| 11 | Бичиг хэргийн зардал | | | | 328,284 | |
| Нийт өртөг | | | | | **33,674,500** | |

*Тайлбар: Зөвлөхөд олгох 1 хүн өдрийн хөлсийг Үндэсний Статистикийн хорооны мэдээллээр 117,764 төгрөгөөр тооцов.*

БОЛОВСРУУЛСАН:

| | |
|---|---|
| “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН ЗАХИРАЛ | Т.ПҮРЭВХАТАН |
| “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР | З.ЭНХ-ОРГИЛ |
| ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН | Н.БАТЖИЛМАА |
| ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН | С.АРИУНЖАРГАЛ |

ХЯНАСАН:

ХББОСЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Д.ГАНТУЛГА

ХББОСЯ-НЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.АРИУНСАНАА

ХББОСЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Т.БАТЦЭНД